

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Хөвсгөл Ус суваг” ХХК -ийн 2024 оны санхүүгийн тайлан, тодруулгад хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан.

Аудитын код: ХӨА-2025/015/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас:
www.audit.mn

Хөвсгөл аймаг
2025 он

Дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089116 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Давааням

Утас: 92113932 Цахим хаяг: davaanyamb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	5-9
3.1 Компани, түүний үйл ажиллагаа	9
3.2 Компанийн гадаад, дотоод орчин	9-10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад гарсан өөрчлөлт	10-16
4. Аудитын тайлан	16
4.1 Ерөнхий зүйл	16
4.2 Материаллаг байдал	16
4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.4 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. Аудитын илрүүлэлт	17-19
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	20

Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
НБББББ	Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлогын Баримт Бичиг
ОНӨҮГ	Орон Нутгийн Өмчит Үйлдвэрийн Газар



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

“ХӨВСГӨЛ УС СУВАГ” ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ч. БАТСҮХ
ТАНАА

2025.03.14 № 1/294
танай _____-ны № _____-т

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Хөвсгөл Ус суваг” ХХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлангийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Орон нутгын өмчийн газрын даргын А/66-р тушаалаар 288.0 сая төгрөгийн гинжит трактор, Аймгийн ИТХ-ын 07-р тогтоолоор 1,3,4,5-р хорооны 1,000м 908.7 сая төгрөгийн цэвэр бохир усны шугам сүлжээг, 08-р тогтоолоор 69.3 сая төгрөгийн Ухаалаг худгийг орлогод авч үндсэн хөрөнгийг нэмэгдүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй

Тус байгууллага нь Зорилтод түвшний орлогын төлөвлөгөөг 21.3 сая төгрөгөөр дутуу бүрдүүлсэн, 0.8 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан, 128.9 сая төгрөгийн өр төлбөр үүсгэсэн, ахмадын сан байгуулж ажиллаагүй, НБББББ боловсруулж мөрдөөгүй, дотоод хяналт хэрэгжүүлээгүй зэрэг зөрчил илэрсэн.

Бусад асуудлын хэсэг

“Хөвсгөл Ус Суваг” ХХК нь тусгай зөвшөөрлийн хүрээнд усан хангамжийн эх үүсвэрийн 5 худаг, цэвэр усны II өргөлтийн насост станц цэвэр усны төв болон салбар 52.1 км шугам сүлжээ, бохир усны төв болон салбар 44.7 км шугам сүлжээгээр дамжуулан төсөвт болон аж ахуйн нэгжийн 317 байгууллага, 57 орон сууцны 2599 айл өрх, хувийн сууцтай 534 /гэр хорооллын/ айл өрхийг цэвэр усаар хангаж, бохир усыг татан зайлуулах үйлчилгээг үзүүлж байна.

6720022082

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АЭРДЭНЭБААТАР



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	19,857,477.74	17,186,741.37
1.1.2	Дансны авлага	266,052,280.15	174,840,352.96
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	0.00	70,027.47
1.1.6	Бараа материал	531,587,284.80	465,673,716.34
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	93,831,636.37	0.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	911,328,679.06	657,770,838.14
1.2.1	Үндсэн хөрөнгө	5,011,058,057.76	17,055,096,272.84
1.2.2	Биет бус хөрөнгө	3,634,328,678.82	3,626,440,681.80
1.2.9	Дуусаагүй барилга	9,475,600,265.45	0.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	18,120,987,002.03	20,681,536,954.64
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	19,032,315,681.09	21,339,307,792.78
2.1.1.1	Дансны өглөг	17,419,712.01	81,293,027.46
2.1.1.3	Татварын өр	88,402,306.66	74,451,756.26
2.1.1.6	Хүүний өглөг	544,149,712.46	544,149,712.46
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	0.00	4,000,000.00
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	572,063.12	632,662.12
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	650,543,794.25	704,527,158.30
2.1.2.1	Урт хугацаат зээл	11,352,891,846.29	12,765,185,465.58
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	11,352,891,846.29	12,765,185,465.58
2.2	Өр төлбөрийн нийт дүн	12,003,435,640.54	13,469,712,623.88
2.3	Эздийн өмч	2,245,880,669.67	2,245,880,669.67
2.3.1	төрийн	2,245,880,669.67	2,245,880,669.67
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	657,840,694.47	657,840,694.47
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	5,834,858,652.54	6,986,308,416.24
2.3.9	Хуримтлагдсан ашиг	-1,709,699,976.13	-2,020,434,611.48
2.3.11	Эздийн өмчийн дүн	7,028,880,040.55	7,869,595,168.90
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	19,032,315,681.09	21,339,307,792.78

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Төгрөгөөр

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	3,570,473,896.95	4,080,103,422.07
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	3,452,682,123.41	4,047,455,879.55
3	Нийт ашиг (алдагдал)	117,791,773.54	32,647,542.52
4	Түрээсийн орлого	0.00	0.00
5	Хүүгийн орлого	0.00	0.00
6	Ногдол ашгийн орлого	0.00	0.00
7	Эрхийн шимтгэлийн орлого	0.00	0.00
8	Бусад орлого	0.00	0.00
9	Борлуулалт, маркетингийн зардал	0.00	0.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	285,868,500.98	347,428,104.10
11	Санхүүгийн зардал	0.00	0.00
12	Бусад зардал	0.00	0.00
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	0.00	0.00
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	0.00
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	0.00
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	0.00	0.00
17	Бусад ашиг (алдагдал)	0.00	0.00
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-168,076,727.44	-314,780,561.58
19	Орлогын татварын зардал	0.00	0.00
20	Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-168,076,727.44	-314,780,561.58
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	0.00	0.00
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-168,076,727.44	-314,780,561.58
23	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	0.00	0.00
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00
23.3	Бусад олз (гарз)	0.00	0.00
24	Нийт дэлгэрэнгүй орлогын дүн	-168,076,727.44	-314,780,561.58
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	0.00	0.00

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2,245,880,669.67	657,840,694.47	5,831,314,136.04	(1,518,383,418.95)	7,216,652,081.23
3	Залруулсан үлдэгдэл	2,245,880,669.67	657,840,694.47	5,831,314,136.04	(1,518,383,418.95)	7,216,652,081.23
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(191,316,635.09)	(191,316,635.09)
6	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	3,544,516.50	-	3,544,516.50
9	2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2,245,880,669.67	657,840,694.47	5,834,858,652.54	(1,709,700,054.04)	7,028,879,962.64
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	4,046,004.14	4,046,004.14
11	Залруулсан үлдэгдэл	2,245,880,669.67	657,840,694.47	5,834,858,652.54	(1,705,654,049.90)	7,032,925,966.78
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(314,780,561.58)	(314,780,561.58)
14	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	1,151,449,763.70	-	1,151,449,763.70
17	2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2,245,880,669.67	657,840,694.47	6,986,308,416.24	(2,020,434,611.48)	7,869,595,168.90

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1.1	Мөнгөн орлогын дүн	3,821,516,828.44	4,673,535,513.84
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	3,782,042,205.32	4,178,036,016.62
1.1.6	Бусад мөнгөн орлого	39,474,623.12	495,499,497.22
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	3,969,469,981.88	4,674,206,250.21
1.2.1	Ажиллагчдад төлсөн	1,569,966,165.60	1,773,132,309.73
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	481,861,452.47	497,551,318.65
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	504,908,461.89	582,238,871.45
1.2.4	Ашиглалтын зардал төлсөн	768,982,295.60	918,623,123.50
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	178,243,336.97	146,563,517.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	244,278,264.09	523,418,311.15
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	5,500,000.00	8,041,600.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	215,730,005.26	224,637,198.73
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-147,953,153.44	-670,736.37
2.2	Мөнгөн зарлагын дүн	10,996,700.00	2,000,000.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	10,996,700.00	2,000,000.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-10,996,700.00	-2,000,000.00
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-158,949,853.44	-2,670,736.37
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	178,807,331.18	19,857,477.74
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	19,857,477.74	17,186,741.37

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Мянган төгрөгөөр

№	Үзүүлэлт	2024 оны төлөвлөгөө	2024 оны гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Цалин	2,228,125.5	2,066,672.5	161,453.0	92.8
2	НДШ	278,515.7	262,651.0	15,864.7	94.3
3	Албан томилолт	9,940.0	6,121.3	3,818.8	61.6
4	Шуудан холбоо, хэвлэл захиалга	13,377.0	11,416.5	1,960.5	85.3
5	Бичиг хэрэг	5,654.2	6,531.7	(877.5)	115.5
6	Зар сурталчилгаа	1,000.0	302.4	697.6	30.2
7	Хөдөлмөр хамгаалал	42,515.1	37,469.9	5,045.2	88.1
8	Нормын сүү	36,330.0	32,172.9	4,157.1	88.6
9	ХХХувцас, хэрэгсэл/ өвөл, зуны /	43,856.1	35,891.5	7,964.6	81.8
10	Түлш шатахуун	181,824.3	175,597.6	6,226.7	96.6
11	Сургалт	17,487.4	10,012.4	7,475.0	57.3
12	Үндсэн хөрөнгийн элэгдэл	539,386.1	676,624.9	(137,238.8)	125.4
13	Ариутгал цэвэрлэгээ	24,726.4	20,577.5	4,148.9	83.2
14	Шинжилгээ	6,456.1	6,421.9	34.2	99.5
15	Цэвэрлэх байгууламжийн химийн бодис	8,713.1	8,636.4	76.7	99.1
16	Цахилгааны сэлбэг	13,151.2	17,236.6	(4,085.4)	131.1
17	Сантехникийн сэлбэг, багаж хэрэгсэл	34,362.5	38,241.8	(3,879.3)	111.3
18	УХЦБ салбарын урсгал засвар	14,624.0	16,853.3	(2,229.3)	115.2
19	ДХХУсны салбарын засвар	10,036.0	13,954.8	(3,918.8)	139.0
20	ГХУХ салбарын урсгал засвар	9,605.5	9,112.8	492.7	94.9
21	ЦХАТУ-ний салбарын урс засвар	400.5	139.6	260.9	34.9
22	Машин механизмын сэлбэг	22,357.0	18,207.1	4,149.9	81.4
23	цахилгаан	361,553.5	371,804.5	(10,251.0)	102.8

24	халаалт	45,696.5	45,696.5	-	100.0
25	түлээ	19,976.9	28,887.0	(8,910.1)	144.6
26	нүүрс	307,800.0	308,574.3	(774.3)	100.3
27	НСАХ шагнал	29,000.0	16,409.1	12,590.9	56.6
28	Хөрөнгийн даатгал	5,500.0	5,500.0	-	100.0
29	Жолоочийн хариуцлагын даатгал	1,024.9	2,541.6	(1,516.7)	248.0
30	Газар ус ашигласны төлбөр	2,200.0	2,200.0	-	100.0
31	Үл хөдлөх хөрөнгийн татвар	39,691.7	36,591.4	3,100.3	92.2
32	Тээврийн хэрэгслийн татвар	1,206.1	1,060.2	145.9	87.9
33	Газрын төлбөр	8,885.4	8,885.4	-	100.0
34	Гадны байгууллагын хөлс	38,317.0	38,654.8	(337.8)	100.9
35	ТУЗ-ын зардал	43,039.2	42,017.1	1,022.1	97.6
36	Тусламж, тэтгэмж бусад зардал	89,929.5	84,069.6	5,859.9	93.5
Зардал		4,536,264.4	4,463,737.9	72,526.5	98.4
Орлого		3,666,279.2	3,644,934.5	21,344.7	99.4
Ашиг, алдагдал		(869,985.2)	(818,803.4)	(51,181.8)	94.1
Улсын татаас		467,077.4	504,022.8	(36,945.4)	107.9
Татаасны дараах ашиг, алдагдал		(402,907.8)	(314,780.6)	(88,127.2)	78.1

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Компанийн үйл ажиллагаа

Хөвсгөл Ус Суваг" ХХК нь 1972 оноос Ус нийтийн аж ахуйн газар нэртэйгээр ажиллаж байгаад 2016 оны 9 дүгээр сарын 06-ны өдрийн Хөвсгөл аймгийн ИТХ-ын 56 тогтоолыг үндэслэн одоогийн "Хөвсгөл ус суваг" ХХК-ийг байгуулан өөрийн бүтэц зохион байгуулалтаар үйл ажиллагаагаа 6 салбар нэгжтэйгээр явуулж байна.

Тус байгууллагын 2024 оны эдийн засгийн үзүүлэлт, зорилтод түвшнийг аймгийн ИТХХ-ны 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн ээлжит бус ХХIV хуралдааны 13 дугаар тогтоолоор баталсан байна. Тус тогтоолд ажиллагсдын тоог нийт 146 байхаар баталсан байна.

"Хөвсгөл Ус Суваг" ХХК нь тусгай зөвшөөрлийн хүрээнд усан хангамжийн эх үүсвэрийн 5 худаг, цэвэр усны II өргөлтийн насост станц цэвэр усны төв болон салбар 52.1 км шугам сүлжээ, бохир усны төв болон салбар 44.7 км шугам сүлжээгээр дамжуулан төсөвт болон аж ахуйн нэгжийн 317 байгууллага, 57 орон сууцны 2599 айл өрх, хувийн сууцтай 534 /гэр хорооллын/ айл өрхийг цэвэр усаар хангаж, бохир усыг татан зайлуулах үйлчилгээг үзүүлж байна.

Мөн зөөврийн ус хангамжийн 3 автомашин, 19 зөөврийн ус түгээх байр, 1 гүний эх үүсвэртэй ус түгээх байр 24 цагийн тасралтгүй үйл ажиллагаатай 32 ухаалаг ус түгээх байраар гэр хорооллын 13,911 өрхийн 42,911 хүн амыг ундны цэвэр усаар ханган ажиллаж, төвлөрсөн халаалтын шугам сүлжээнд холбогдоогүй 2 сургууль, 4 цэцэрлэг, 1 үйлдвэрийн газар нийт 16 төсөвт болон аж ахуйн нэгж, 114 айл өрхийг бие даасан 5 халаалтын зуухнаас дулааны эрчим хүчээр хангах ажлыг гүйцэтгэсэн байна.

Тайлант онд төвлөрсөн шугам сүлжээгээр 422,757.0 мянган м3 (1,158.2 м3/хон) усыг олборлон, 414,312.0 мянган м3 (1,135.1 м3/хон) бохир усыг татан зайлуулсан байна.

"Хөвсгөл Ус Суваг" ХХК-ийн Эрхэм зорилго

Хэрэглэгчдийн хэрэглээний цэвэр ус , дулааныг горимыг дагуу түгээх, бохир усыг татан зайлуулах, инженерийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэн, нийтийн үйлчилгээг соёлч, шуурхай хүргэх, удирдлага санхүүгийн хувьд бие дааж ажиллахад оршино гэсэн зорилгыг тавьж ажилласан байна. Зорилгоо биелүүлэхийн тулд дараах зорилтыг дэвшүүлсэн байна. Үүнд:

- Шинэ техник, технологи, автоматжуулалт, шинэ санал санаачилга, туршлага нэвтрүүлэх
- Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар айл өрх, ААН байгууллагыг төвлөрсөн шугам сүлжээнд холбож, хэрэглэгчээ нэмэгдүүлэх
- Эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх /орлого, зардал, авлага/

- Цэвэр усны хэмнэлт, үнэ тарифыг нэмэгдүүлэх ажилчдын сахилга, хариуцлага, цаг ашиглалт, Цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагааг жигдрүүлэх
- Зардал нөхөх төлөвлөгөө мөрдөж, НББ-ийг улам сайжруулж, аудитаас өгсөн зөвлөмжийн дагуу Төрийн хэмнэлтийн хуулийг хэрэгжүүлж ажиллах
- ИТА, мэргэжилтэй ажилтан бэлтгэх сургалтад хамруулж, хүний нөөцийг бэхжүүлэх
- Ажилчдын орон тоог нягтруулж, нийгмийн баталгааг нэмэгдүүлэх
- Нийт ажилчдын дунд жилд 2 удаа тэмцээн, уралдааныг зохион байгуулах гэсэн зорилтуудыг тавьж ажилласан байна.

“Хөвсгөл Ус Суваг” ХХК-ийн гүйцэтгэх захирал нь ТУЗ-ийн 2024 оны 01 дүгээр тогтоолоор бизнес төлөвлөгөөгөө батлуулж, хэрэгжүүлэн ажилласан байна.

3.2 Компанийн гадаад, дотоод орчин.

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар:

Тус байгууллага нь Компанийн тухай хууль, Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Нийгмийн даатгалын шимтгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон бусад хууль тогтоомж журам зааврыг мөрдөн ажилласан байна.

Тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт орсон байна.

Хөвсгөл Ус Суваг” ХХК-ийн дүрмийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 105 дугаар тогтоолын хавсралтаар баталж 2022 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр улсын бүртгэлд бүртгүүлсэн байна.

Тайлант хугацаанд компанийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын дотоод хяналтын талаар:

Илрүүлэлт: Тус байгууллагын дотоод аудитораар ажиллаж байсан албан хаагч 2024 оны 07 дугаар сард ажлаасаа чөлөөлөгдсөн байхад 2024 оны 12 дугаар сард дотоод аудиторыг томилсон байна. Тайлант онд Дотоод хяналтын төлөвлөгөө тайлан боловсруулаагүй, хяналт хэрэгжүүлээгүй байна. Энэ нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-тай нийцээгүй “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж өгөх.

Тухайн байгууллагад дээд шатны байгууллагаас тайлант онд дотоод аудитыг хэрэгжүүлээгүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“Хөвсгөл Ус Суваг” ХХК нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Компанийн тухай хууль болон СТОУС, түүнд нийцүүлэн баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар:

Илрүүлэлт: “Хөвсгөл Ус Суваг” ХХК нь байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2. “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж өгөх.

Санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа НББОУС, Засгийн газар, Сангийн яамнаас гаргасан журам, зааврыг мөрдөж ажилласан байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

“Хөвсгөл Ус Суваг” ХХК -ийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн гол бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2.307.0 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №-1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	19,857.5	17,186.7	(2,670.7)
Авлага	266,052.3	174,840.4	(91,211.9)
Бараа материал	531,587.3	465,673.7	(65,913.6)
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	93,831.6	-	(93,831.6)
Үндсэн хөрөнгө	5,011,058.1	17,055,096.3	12,044,038.2
Биет бус хөрөнгө	3,634,328.7	3,626,440.7	(7,888.0)
Дуусаагүй барилга	9,475,600.3	-	(9,475,600.3)
Нийт хөрөнгө	19,032,315.7	21,339,307.8	2,306,992.1
Богино хугацаат өр төлбөр	650,543.8	704,527.2	53,983.4
Урт хугацаат зээл	11,352,891.8	12,765,185.5	1,412,293.6
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	657,840.7	657,840.7	-
Эздийн өмчийн бусад хэсэг	5,834,858.7	6,986,308.4	1,151,449.8
Хуримтлагдсан ашиг	(1,709,700.0)	(2,020,434.6)	(310,734.6)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	19,032,315.7	21,339,307.8	2,306,992.1

Хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө 2.7 сая төгрөг, авлага 91.2 сая төгрөг, бараа материал 65.9 сая төгрөг, биет бус хөрөнгө 7.9 сая төгрөг, дуусаагүй барилга 9,475.6 сая төгрөгөөр буурч, үндсэн хөрөнгө 12,044.0 сая төгрөг, өр төлбөр 1,466.3 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд банкин дахь мөнгөн хөрөнгө 16.7 сая төгрөг, касс дахь мөнгөн хөрөнгө 0.5 сая төгрөг байна.

Борлуулалтын авлага 174.8 сая төгрөг, бусад авлага 0.01 сая төгрөг нийт 174.8 сая төгрөгийн авлага бүртгэлтэй байна.

Тайлант онд 942.5 сая төгрөгийн бараа материалыг худалдан авч, 1,008.4 сая төгрөгийн материалыг зарцуулснаар бараа материалын үлдэгдэл 465.7 сая төгрөг болж буурсан байна.

Үндсэн хөрөнгө нэмэгдсэн нь цэвэрлэх байгууламжийг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэж орлого авсантай холбоотой байна. Үүнд:

- Цэвэрлэх байгууламжийг нөөцийн бараа данснаас Барилга байгууламж дансанд шилжүүлэн бүртгэсэн 9,036.3 сая төгрөг,

- Машин тоног төхөөрөмж 2,768.6 сая төгрөг,
- Тээврийн хэрэгсэл 489.4 сая төгрөг,
- Тавилга эд хогшил 19.9 сая төгрөг,
- Компьютер тоног төхөөрөмж 19.9 сая төгрөг,
- Бусад 5.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг авсан байна.

Үндсэн хөрөнгийн данснаас 195.3 сая төгрөгийн тээврийн хэрэгслийг хасаж 46.0 сая төгрөгөөр үнэ шинэчлэн ашиглалтын хугацааг дохин тогтоосон байна.

Хөвсгөл аймгийн Засаг дарга, Сангийн яамтай байгуулсан MON7313 гэрээний дагуу 7,394.9 сая төгрөгөөр Хөвсгөл аймагт цэвэрлэх байгууламж барьсан зардлыг орон нутгийн төсвөөс төлж барагдуулах гэрээ хийсэн байна. Тайлант онд Хөвсгөл ус суваг ХХК-ийн цэвэрлэх байгууламжийн урт хугацаат өр төлбөрийн дүн валютын ханшийн зөрүүнээс хамаарч 1,412.3 сая төгрөгөөр нэмэгдэж нийт 12,765.2 сая төгрөг болсон байна.

1. Илрүүлэлт: Тайлант онд дансны өглөг 81.3 сая төгрөг, татварын өглөг 47.0 сая төгрөг, бусад богино хугацаат 0.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8. "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 8/ "өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх" гэсэн заалт болон "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Дансны өглөг, төлбөр тооцоог хянах, ажил, гүйлгээг гаргахаас өмнө хянан, баталгаажуулж өр төлбөр үүсгэхгүй ажиллах зөвлөмж өгөх.

2. Илрүүлэлт: Тайлант үеийн ашиг алдагдлын дүн санхүүгийн байдлын тайлан болон өмчийн өөрчлөлтийн тайлангаас 4,045,926.23 мөнгөөр зөрүүтэй тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4. үнэн зөв байх гэсэн заалттай нийцээгүй бөгөөд "Үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Аудитын хугацаанд залруулан.

3. Илрүүлэлт: Эздийн өмчийн бусад хэсгийн дүн санхүүгийн байдлын тайлан болон өмчийн өөрчлөлтийн тайлангаас 1,470,981,744.04 мөнгөөр зөрүүтэй тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4. үнэн зөв байх гэсэн заалттай нийцээгүй бөгөөд "Үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Аудитын хугацаанд залруулсан.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл.

3.5.1 Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Гүйцэтгэх захирал нь үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө /техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Хөвсгөл Ус суваг ХХК-ийн 2024 оны Зорилтот түвшний төлөвлөгөөг анх ТУЗ-ийн 2024 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор зардлыг 4,536.3 сая төгрөгөөр, борлуулалтын орлогыг 3,666.3 сая төгрөгөөр, улсын төсвийн татаас 467.1 сая төгрөг нийт 4,133.4 сая төгрөг буюу 402.9 сая төгрөгийн алдагдалтай баталсан байна.

Хөвсгөл Ус суваг ХХК-ийн 2024 оны Зорилтот түвшний төлөвлөгөөнд 2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 04 дүгээр тогтоол, 07 дугаар сарын 26-ны өдрийн 12 дугаарт тогтоол, 09 дүгээр сарын 11-ны өдрийн 06 дугаар тогтоолоор 3 удаагийн тодотгол хийсэн байна.

Хөвсгөл Ус суваг ХХК-ийн 2024 оны Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт №-2.

Мянган төгрөгөөр

№	Үзүүлэлт	2024 оны төлөвлөгөө	2024 оны гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Цалин	2,228,125.5	2,066,672.5	161,453.0	92.8
2	НДШ	278,515.7	262,651.0	15,864.7	94.3

3	Албан томилолт	9,940.0	6,121.3	3,818.8	61.6
4	Шуудан холбоо, хэвлэл захиалга	13,377.0	11,416.5	1,960.5	85.3
5	Бичиг хэрэг	5,654.2	6,531.7	(877.5)	115.5
6	Зар сурталчилгаа	1,000.0	302.4	697.6	30.2
7	Хөдөлмөр хамгаалал	42,515.1	37,469.9	5,045.2	88.1
8	Нормын сүү	36,330.0	32,172.9	4,157.1	88.6
9	ХХХувцас, хэрэгсэл/ өвөл, зуны /	43,856.1	35,891.5	7,964.6	81.8
10	Түлш шатахуун	181,824.3	175,597.6	6,226.7	96.6
11	Сургалт	17,487.4	10,012.4	7,475.0	57.3
12	Үндсэн хөрөнгийн элэгдэл	539,386.1	676,624.9	(137,238.8)	125.4
13	Ариутгал цэвэрлэгээ	24,726.4	20,577.5	4,148.9	83.2
14	Шинжилгээ	6,456.1	6,421.9	34.2	99.5
15	Цэвэрлэх байгууламжийн химийн бодис	8,713.1	8,636.4	76.7	99.1
16	Цахилгааны сэлбэг	13,151.2	17,236.6	(4,085.4)	131.1
17	Сантехникийн сэлбэг, багаж хэрэгсэл	34,362.5	38,241.8	(3,879.3)	111.3
18	УХЦБ салбарын урсгал засвар	14,624.0	16,853.3	(2,229.3)	115.2
19	ДХХУсны салбарын засвар	10,036.0	13,954.8	(3,918.8)	139.0
20	ГХУХ салбарын урсгал засвар	9,605.5	9,112.8	492.7	94.9
21	ЦХАТУ-ний салбарын урс засвар	400.5	139.6	260.9	34.9
22	Машин мөхнзмнн сэлбэг	22,357.0	18,207.1	4,149.9	81.4
23	цахилгаан	361,553.5	371,804.5	(10,251.0)	102.8
24	халаалт	45,696.5	45,696.5	-	100.0
25	түлээ	19,976.9	28,887.0	(8,910.1)	144.6
26	нүүрс	307,800.0	308,574.3	(774.3)	100.3
27	НСАХ шагнал	29,000.0	16,409.1	12,590.9	56.6
28	Хөрөнгийн даатгал	5,500.0	5,500.0	-	100.0
29	Жолоочийн хариуцлагын даатгал	1,024.9	2,541.6	(1,516.7)	248.0
30	Газар ус ашигласны төлбөр	2,200.0	2,200.0	-	100.0
31	Үл хөдлөх хөрөнгийн татвар	39,691.7	36,591.4	3,100.3	92.2
32	Тээврийн хэрэгслийн татвар	1,206.1	1,060.2	145.9	87.9
33	Газрын төлбөр	8,885.4	8,885.4	-	100.0
34	Гадны байгууллагын хөлс	38,317.0	38,654.8	(337.8)	100.9
35	ТУЗ-ын зардал	43,039.2	42,017.1	1,022.1	97.6
36	Тусламж, тэтгэмж бусад зардал	89,929.5	84,069.6	5,859.9	93.5
Зардал		4,536,264.4	4,463,737.9	72,526.5	98.4
Орлого		3,666,279.2	3,644,934.5	21,344.7	99.4
Ашиг, алдагдал		(869,985.2)	(818,803.4)	(51,181.8)	94.1
Улсын татаас		467,077.4	504,022.8	(36,945.4)	107.9
Татаасын дараах ашиг, алдагдал		(402,907.8)	(314,780.6)	(88,127.2)	78.1

Тайлант онд нийт 3,666.3 сая төгрөгийн орлого олж 4,394.9 сая төгрөгийн зардал гаргаж 314.8 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Тайлант онд цэвэр ашиг -314.8 сая төгрөг болсон нь өмнөх оноос 146.7 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

3.5.2 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт.

Тус байгууллагын 2024 оны эдийн засгийн үзүүлэлт, зорилтод түвшнийг аймгийн ИТХХ-ны 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн ээлжит бус XXIV хуралдааны 13 дугаар тогтоолоор баталсан байна. Тус тогтоолд нийт зардлыг 4,536.3 сая төгрөг, орлогыг 3,666.3 сая төгрөг, элэгдэл хорогдлын зардлыг 539.4 мянган төгрөг, ашиг алдагдлыг -870.0 сая төгрөгийн алдагдалтайгаар баталсан байна. Үүнийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт №-3.

Мянган төгрөгөөр

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2024 оны төлөвлөгөө	2024 оны гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Үйлдвэрлэсэн цэвэр бохир ус	м3	232.4	381.2	148.9	164.1
2	Зайлуулсан бохир ус	м3	283.1	302.3	19.3	106.8
3	Гэр хорооллын цэвэр ус	м3	101.6	76.3	(25.3)	75.1

ундаа худалдан авах"-гүй байх гэсэн заалттай нийцээгүй, Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын хугацаанд зориулалт бусаар зарцуулсан 0.8 сая төгрөгийг Төрийн сангийн Хө.Бусад нэр заагдаагүй орлого 100170000955 тоот дансанд тушааж төсөвт учирсан хохирлыг бүрэн барагдуулж залруулсан.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4,000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны дансны тухай хуулийн хэрэгжилтийг хянаж үзэхэд мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж ажилласан бөгөөд алдаа зөрчилтэй асуудал илрээгүй.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2. Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Илрүүлэлт: Малын гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрүүдийн зөөврийн бохир ус татан зайлуулах үнэ тарифыг шинэчлэн тогтоохдоо Зохицуулах хороонд санал хүргүүлж батлуулалгүй “Хөвсгөл Ус Суваг” ХХК-ийн ТУЗ-ийн 2024.07.26-ны өдрийн 11 дүгээр тогтоолоор үнэ тарифыг шинэчлэн тогтоосон нь хууль эрх зүйн үндэслэлгүй байна. Энэ нь Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.6 үйлчилгээний тарифын хэмжээ тогтоох саналыг боловсруулж, Зохицуулах хороогоор батлуулж, мөрдөх гэсэн заалттай нийцээгүй бөгөөд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж өгөх

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар хийсэн ажил, үр дүнгийн талаар товч бичнэ. Хэрвээ асуудлын бүртгэлээр зөвлөмж өгсөн бол биелэлтийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянаж үр дүнг аудитын тайланд тусгана. Биелэлт хангалтгүй бол тайлант оны буруу илэрхийллийн дүнд оруулна.

Завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитыг 2024 оны 3 дугаар улирлын байдлаарх санхүүгийн баримт материал, бүртгэл тайлагналыг хамруулан гүйцэтгэхэд алдаа зөрчилтэй асуудал илрээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 70.2 сая төгрөгийн 1 албан шаардлага, 88.4 сая төгрөгийн 5 зөвлөмжийг өгсөн байна.

Хүснэгт 5. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		/мянган төгрөгөөр/ Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	70.2	1	70.2	100.0
Зөвлөмж	5	88.4	5	88.4	100.0
Нийт дүн	6	158.6	6	158.6	100.0

4	Үйлдвэрлэсэн дулаан	Г.кал	63.5	19.7	(43.8)	31.0
5	Халуун усны үйлчилгээ	хүн	25.1	35.2	10.1	140.3
6	Нийт орлого	төгрөг	3,666,279.2	3,644,934.5	(21,344.7)	99.4
7	Нийт зардал	төгрөг	4,536,264.4	4,463,737.9	(72,526.5)	98.4
8	Үүнээс элэгдэл тооцох	төгрөг	539,386.1	676,624.9	137,238.8	125.4
9	Борлуулалтын /нэгж бүтээгдэхүүний өртөг өссөн буурсан/	төгрөг	1	1	-	100.0
11	Авлага /бууралт/	төгрөг	85,000.0	131,362.9	46,362.9	154.5
13	Богино хугацаат өглөг	төгрөг	559,149.7	559,149.7	-	100.0
15	Үйл ажиллагааны ашиг алдагдал	төгрөг	(869,985.2)	(818,803.4)	51,181.8	94.1
18	Нийт ажиллагсдын тоо	төгрөг	146	126	(20)	86.3
19	Нийт цалингийн сан	төгрөг	2,228,125.5	2,066,672.5	(161,453.0)	92.8
20	Нийт зардалд цалингийн сангийн эзлэх хувь		49	46	(3)	94.3

Гүйцэтгэлээр зорилтод түвшний ашиг алдагдал 818.8 сая төгрөг байна.

Орлогын төлөвлөгөөний биелэлтийн талаар:

Тайлант оны нийт орлогыг 3,666.3 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 3,644.9 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, зорилтод түвшнийг 21.3 сая төгрөг буюу 11.8 хувиар дутуу төвлөрүүлсэн байна.

Борлуулалтын орлогын бүтэц, гүйцэтгэлийг хүснэгтээр баруулбал:

Хүснэгт №-3.

/Мян.төг/

№	Орлогын бүтэц	2024 оны төлөвлөгөө	2024 оны орлогын гүйцэтгэл	Зөрүү	Гүйцэтгэлийн хувь
1	Шугам хоолойн цэвэр ус	435,837.8	476,629.5	40,791.7	109.4
2	Шугам хоолойн бохир ус	1,007,380.5	1,055,554.1	48,173.5	104.8
3	Суурь хураамж /албан байгууллага	45,563.5	42,282.2	(3,281.3)	92.8
4	Албан байгууллагын халаалт	813,033.3	720,256.7	(92,776.6)	88.6
5	Айл өрхийн халаалт	34,504.6	34,798.4	293.8	100.9
6	Орон сууцны цэвэр ус	194,461.1	202,227.9	7,766.8	104.0
7	Орон сууцны бохир ус	413,178.2	397,093.0	(16,085.2)	96.1
8	Суурь хураамж /айл өрх/	65,263.5	54,743.0	(10,520.5)	83.9
9	Зөөврийн цэвэр ус	11,398.2	3,241.3	(8,156.9)	28.4
10	Зөөврийн бохир ус	96,600.0	133,532.8	36,932.8	138.2
11	Халуун усны орлого	110,431.8	132,532.5	22,100.7	120.0
12	Худгийн орлого	258,086.9	254,195.8	(3,891.1)	98.5
13	Усан сангийн орлого	104,499.9	84,910.8	(19,589.1)	81.3
14	Түрээсийн орлого	9,039.8	12,079.7	3,039.9	133.6
15	Шинэ холболтын хураамжийн орлого	4,000.0	2,110.0	(1,890.0)	52.8
16	Слесарийн засвар үйлчилгээний орлого	20,000.0	25,301.8	5,301.8	126.5
17	Машин механизмын орлого	10,000.0	4,570.0	(5,430.0)	45.7
18	Усны тоолуурын үйлчилгээний орлого	8,000.0	4,020.0	(3,980.0)	50.3
19	Угаалгын газар, хими цэвэрлэгээ	25,000.0	4,855.0	(20,145.0)	19.4
Дүн		3,666,279.2	3,644,934.5	21,344.7	88.2

Хүснэгтээс харахад дараах орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлсэн байна. Үүнд:

- Шугам хоолойн цэвэр ус 40.7 сая
- Шугам хоолойн бохир ус 48.2 сая

- Зөөврийн бохир ус 36.9 сая
- Халуун усны орлого 22.1 сая
- Түрээсийн орлого 3.0 сая
- Слесарийн засвар үйлчилгээний орлого 5.3 сая төгрөг нийт 164.4 сая төгрөгийн орлогыг нэр төрлөөр нь давуулан биелүүлсэн байна.

Дээрх орлогоос бусад орлогыг дутуу төвлөрүүлсэн бөгөөд нэр төрлөөр авч үзвэл нийт 181.8 сая төгрөгийн орлогын төлөвлөгөөг тасалсан байна.

Илрүүлэлт: Зорилтод түвшний орлогыг нийт 21.3 сая төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн Захирал дараахь эрх, үүрэгтэй: 3/“үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах” гэсэн заалттай нийцээгүй бөгөөд “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдэлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Иймд батлагдсан орлогын зорилтот түвшнийг бүрэн биелүүлж ажиллах зөвлөмж өгөхөөр шийдвэрлэсэн.

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

2024 онд гадаад, дотоодын эх үүсвэрээр ямар нэгэн төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Хөвсгөл Ус суваг ХХК нь тайлант онд 26 нэр төрлийн 1,426.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй бараа ажил үйлчилгээг худалдан авсан байна.

Хүснэгт №-4.

Мөрдсөн журам	Бараа ажил, үйлчилгээ	Төсөвт өртөг /мян.төг/	Гэрээ байгуулсан дүн /мян.төг/	Хэмнэлт /мян.төг/
Нээлттэй тендер	3	599.6	556.2	43.4
Хязгаарлагдмал тендер	1	407.3	407.3	-
Харьцуулалтын арга	9	288.4	288.4	-
Шууд худалдан авалт	13	131.5	124.8	6.7
Нийт	26	1,426.8	1,376.7	50.1

Тайлант онд засвар үйлчилгээ, хөрөнгө оруулалтын зардалд 226.3 сая төгрөг, шатахуун тослох материалын зардалд 181.8 сая төгрөг, нүүрс түлээний зардалд 327.8 сая төгрөг, бичиг хэргийн зардалд 5.6 сая төгрөг, хөдөлмөр хамгааллын зардалд 181.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй бараа ажил үйлчилгээг худалдан авах ажиллагааг тус тус зохион байгуулсан байна.

Худалдан авах ажиллагааны төсөвт өртгийн 42.0 хувийг нээлттэй тендер шалгаруулалтаар, 28.5 хувийг Хязгаарлагдмал тендер шалгаруулалтаар, харьцуулалтын аргаар 20.2 хувийг, 9.2 хувийг шууд худалдан авалтын аргаар зохион байгуулсан байна.

Худалдан авах ажиллагааны үр дүнд 50.1 сая төгрөгийн хэмнэлтийг гаргаж ажилласан байна.

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг Tender.gov.mn цахим системд байршуулж ажилласан байна.

Тайлант онд худалдан авсан бараа ажил үйлчилгээ нь Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуультай нийцсэн, Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолоор баталсан босго үнийг баримтлан ажилласан байна.

3.6. Үндэсний аудитын газраас ирүүлсэн ерөнхий чиглэлийн хүрээнд авсан судалгааны үр дүнгийн талаар:

- Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолоор "Ахмадын сан байгуулан ажиллуулах журам"-ыг шинэчлэн баталсан байна. Тус газар нь ахмадын сан байгуулж ажиллаагүй нь Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 "Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах бөгөөд Ахмадын сан байгуулан ажиллуулах журмыг Засгийн газар батална" заалттай нийцэхгүй, "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул ахмадын сан байгуулж ажиллах зөвлөмж өгөхөөр шийдвэрлэсэн.
- Тус газар газар нь тайлант онд бараа ажил үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөг shilendans.gov.mn цахим хуудсанд байршуулсан, худалдан авах ажиллагааны тухай хууль, журмыг баримтлан ажилласан байна.
- Орон тооны судалгааны үр дүнгээс харахад нийт 145 орон тоо батлагдсан бөгөөд 127 орон тоогоор ажилласан байна.

Ерөнхий чиглэлийн хүрээнд авсан судалгааны үр дүнд илсэн зөрчилтэй асуудлуудыг аудитын тайланд тусгасан болно.

АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу "Хөвсгөл Ус Суваг" ХХК -ийн 2024 оны оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх компани/ТӨҮГ, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн компанийн үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Давааням гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Тэгшдэлгэр, дарга тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар хэрэгжүүлсэн.

"Хөвсгөл Ус Суваг" ХХК -ийн 2024 оны санхүүгийн тайланг Төрийн аудитын газарт 2025 оны 02 дугаар сарын 14-ны өдрийн 25 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн 4,394.9 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 87.9 сая төгрөгөөр, Санхүүгийн тайлангийн түвшинд гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 49.4 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд горим сорил хэрэгжүүлэхэд дараах зөрчилтэй асуудал илэрлээ. Үүнд:

Илрүүлэлт: Тус байгууллагын төсвөөс 0.8 сая төгрөгийн архи, согтууруулах ундаа, бэлтгэж төсвийг хэмнэлтгүй, үр ашиггүй, зориулалт бусаар, зарцуулсан байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.7-д "байгууллагын төсвөөр согтууруулах

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж албан шаардлагыг хэрэгжүүлэн ажиллаж биелэлтийг гаргасан байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тус байгууллагын эдийн засгийн үзүүлэлт, зорилтод түвшнийг алдагдалтайгаар баталж байгааг дараагийн аудитаар анхаарах шаардлагатай гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 151.1 сая төгрөгийн зөрчил илэрснээс 0.8 сая төгрөгийн зөрчлийг аудитын хугацаанд залруулж төсвийг хохиролгүй болгож, 150.3 сая төгрөгийн зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх 6 зөвлөмж өгсөн.

Аудитаар Нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой 1,475.0 сая төгрөгийн 2 алдаа илэрснийг аудитын явцад залруулсан.

5.1 Төлбөрийн акт

Төсөвт учирсан хохирлыг аудитын хугацаанд барагдуулсан тул төлбөрийн акт тогтоогоогүй болно.

5.2 Албан шаардлага.

Аудитаар албан шаардлага тогтоогоогүй болно.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Дотоод хяналт хариуцлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд Дотоод хяналтын төлөвлөгөө тайлан боловсруулаагүй, хяналт хэрэгжүүлээгүй байна. Энэ нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-тай нийцээгүй “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Дотоод хяналтын төлөвлөгөө боловсруулан батлуулж, дотоод хяналтыг үр дүнтэй зохион байгуулж ажиллах.

2. Орлогын төлөвлөгөөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Зорилтод түвшний орлогыг нийт 21.3 сая төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн Захирал дараахь эрх, үүрэгтэй: 3/“үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах” гэсэн заалттай нийцээгүй бөгөөд “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдэлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Орлогын төлөвлөгөөг бүрэн биелүүлж, копанийн ашигт ажиллагааг нэмэгдүүлэх арга хэмжээ авч ажиллах.

3. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тус байгууллага нь ахмадын сан байгуулж ажиллаагүй байна. Энэ нь Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 “Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр “Ахмадын сан” байгуулах бөгөөд Ахмадын сан байгуулан ажиллуулах журмыг Засгийн газар батална” заалттай нийцэхгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ахмад настны тухай Ахмад настны тухай хуульд заасны дагуу Ахмадын сан байгуулж ажиллах.

4. Өр төлбөртэй холбоотой асуудал.

Илрүүлэлт: Тайлант онд дансны өглөг 81.3 сая төгрөг, татварын өглөг 47.0 сая төгрөг, бусад богино хугацаат 0.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8. "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 8/ "өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх" гэсэн заалт болон "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Өр төлбөрийг барагдуулж, өр төлбөр үүсгэхгүй ажиллах.

5. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй холбоотой асуудал.

Илрүүлэлт: "Хөвсгөл Ус Суваг" ХХК нь байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2. Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан мөрдөж ажиллах.

6. Үнэ тарифтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Малын гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрүүдийн зөөврийн бохир ус татан зайлуулах үнэ тарифыг шинэчлэн тогтоохдоо Зохицуулах хороонд санал хүргүүлж батлуулалгүй "Хөвсгөл Ус Суваг" ХХК-ийн ТУЗ-ийн 2024.07.26-ны өдрийн 11 дүгээр тогтоолоор үнэ тарифыг шинэчлэн тогтоосон нь хууль эрх зүйн үндэслэлгүй байна. Энэ нь Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.6. үйлчилгээний тарифын хэмжээ тогтоох саналыг боловсруулж, Зохицуулах хороогоор батлуулж, мөрдөх гэсэн заалттай нийцээгүй бөгөөд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үнэ тарифт өөрчлөлт оруулахдаа эрх бүхий байгууллагад санал хүргүүлж шийдвэрлүүлэн мөрдөж ажиллах.

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5. Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ гэж заасны дагуу аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж ажиллах ажлын төлөвлөгөөг боловсруулан 2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн дотор [Fas.audit.mn](http://fas.audit.mn) сайтад мэдээлж баталгаажуулна уу.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс	
							Залруулсан	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
НББ-ийн тооцооллын алдаа	2	1,475,027.7			2	1,475,027.7	2	1,475,027.7
Зориулалт бус зарцуулалт хийсэн	1	826.1			1	826.1	1	826.1
Дүн	3	1,475,853.8			3	1,475,853.8	3	1,475,853.8

Хүснэгт №-6. Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Зорилтод түвшний орлогыг дутуу төвлөрүүлсэн	1	21,344.7					1	21,344.7
Өр төлбөр үүсгэсэн	1	128,915.8					1	128,915.8
Дотоод хяналт хэрэгжүүлээгүй	1						1	
НБББББ боловсруулж мөрдөөгүй	1						1	
Ахмадын сан байгуулаагүй	1						1	
Үнэ тарифыг нэмэгдүүлэн тогтоосон	1						1	
Дүн	6	150,260.5					6	150,260.5